

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ГЭРЭЭНД ХЭРЭГЛЭХ ХУУЛИЙН ТУХАЙ ГААГИЙН ЗАРЧМУУД

(2015 оны 3 дугаар сарын 19-ний өдөр батлав).

Удиртгал

1. Энэ баримт бичиг нь олон улсын худалдааны гэрээнд хэрэглэгдэх хуулийг сонгохтой холбоотой дөрвөн ерөнхий зарчмыг тогтооно. Зарчмууд нь хараат бус гэрээний тал зарчмыг хязгаарлагдмал тайлбараар баталгаажуулна.
2. Энэ зарчмууд нь нэг орны, бүс нутгийн, олон улсын байгууллагын буюу олон улсын баримт бичигт загвар байдлаар хэрэглэгдэж болно.
3. Энэ зарчмууд нь олон улсын хувийн эрх зүйн дүрмийг тайлбарлах, боловсруулахад хэрэглэгдэж болно.
4. Энэ зарчмуудыг шүүх болон арбитрын шүүх хэрэглэж болно.

1 дүгээр зүйл

Зарчмын хамрах хүрээ

1. Эдгээр зарчмуудыг гэрээний тал бүрийн худалдаа, мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын гэрээнд хэрэглэх хуулийг сонгоход ашиглана. Талууд хэрэглэгчийн болон хөдөлмөрийн гэрээнд хэрэглэхгүй.
2. Эдгээр зарчмуудын зорилгын хувьд талууд нэг улсад үүсгэн байгуулагдаагүй бөгөөд талуудын харилцаа холбоо болон сонгосон хуулиас бусад асуудал нь зөвхөн тухайн гишүүн улстай холбоогүй бол гэрээг олон улсын гэрээ гэж үзнэ.
3. Эдгээр зарчмууд нь дор дурьдсан асуудлыг зохицуулахад чиглэхгүй. Үүнд:
 - a) Хувь хүний чадамж,
 - b) Арбитрийн хэлэлцээр болон шүүхийг сонгох тухай хэлэлцээр,
 - c) Компаниуд буюу хамтрагч этгээд болон тэдгээрийн дотоод харилцаа,
 - d) Дампуурал,
 - e) Гэрээнээс үүсэх өмчлөгчийн эрх ,
 - f) Төлөөлөгч гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээх боломжтой эсэх.

2 дугаар зүйл

Сонгох эрх

1. Гэрээ нь талуудын сонгосон хуулиар зохицуулагдана.
2. Талууд дор дурьдсаныг сонгож болно.
 - а) Гэрээнд бүхэлд нь эсвэл түүний тодорхой хэсэгт нь хэрэглэгдэх хууль,
 - б) Гэрээний өөр өөр хэсэгт хэрэглэх өөр өөр хууль.
3. Талууд хэзээ ч гэрээнд хэрэглэх хуулийг сонгож мөн өөрчилж болно. Талууд гэрээ байгуулагдсаны дараа гэрээнд хэрэглэх хуулийг сонгосон мөн гэрээнд хэрэглэх хуулийн талаар өөрчлөлт оруулсан нь гэрээний хүчин төгөлдөр байдал болон гуравдагч этгээдийн эрхэд нөлөөлөхгүй.
4. Сонгосон хууль болон талууд буюу тэдгээрийн хэлэлцээрийн хооронд заавал хамаарал байхыг шаардахгүй.

3 дугаар зүйл

Хууль зүйн дүрэм, журам

1. Хэргийг хянан шийдвэрлэх газрын хуулиар өөрөөр заагаагүй бол талуудын сонгох хууль нь олон улсын, олон улсын байгууллагын болон бүсийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн талуудын тэнцвэрийг хадгалсан, тогтвортой хууль зүйн дүрэм, журам байж болно.

4 дүгээр зүйл

Тодорхой болон илэрхий ойлгомжтой сонголт

1. Гэрээнд хэрэглэх хуулийг сонгох болон сонгосон хуулийг өөрчлөх нь гэрээний нөхцөл, зүйл заалтуудад тодорхой тусгагдсан байна. Гэрээнээс үүдэлтэй маргааныг хянан шийдвэрлэх шүүх, арбитрын шүүхэд хэрэглэх эрх зүйн хэмжээг тогтоох тухай талуудын хоорондын хэлэлцээр нь гэрээнд хэрэглэх хуулиас ялгаатай байна.

5 дугаар зүйл

Гэрээнд хэрэглэх хуулийн хүчин төгөлдөр байдал

1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол гэрээнд хэрэглэх хууль нь гэрээ байгуулахад тавигдах зайлшгүй шаардлагатай зүйлд тооцогдохгүй.

6 дугаар зүйл

Гэрээнд хэрэглэх хуулийг сонгох хэлэлцээр

болон стандарт нөхцөлүүдийн зөрчилдөөн

1. Хоёрдугаар хэсэгт заасан нөхцөл нь:
 - a. Талууд гэрээнд хэрэглэх хуулийг хүлээн зөвшөөрсөн эсэх нь тохирсон улсын хуулиар тодорхойлогдоно,
 - b. Хэрэв талууд 2 өөр хуульд нийцсэн стандарт нөхцөлийг хэрэглэж байгаа бөгөөд тэдгээр 2 хуульд ижил стандарт нөхцөл зонхилж байгаа бол зонхилох стандарт нөхцлийг хамгийн ихээр агуулж байгаа орны хуулийг гэрээнд хэрэглэнэ. Хэрэв тэдгээр 2 хуульд ялгаатай стандарт нөхцөл зонхилж байвал эсвэл тэдгээр 2 хуульд стандарт нөхцөлүүд зонхилоогүй бол гэрээнд хэрэглэх хуулийг тогтоогдсон гэж үзэхгүй.
2. Хэрэв нэгдүгээр хэсэгт тодорхойлогдсон хуулийн дагуу өмнө дурьдсан нөхцөлүүдийн хүрээнд үндэслэлтэй тодорхойлох боломжгүй бол гэрээний тал гэрээнд хэрэглэх хуулийг хүлээн зөвшөөрсөн эсэхийг тухайн гэрээний талын үүсгэн байгуулагдсан улсын хуулиар тодорхойлно.

7 дугаар зүйл

Салангид байдал

Гэрээнд хэрэглэх хуулийг тодорхойлсон заалтыг агуулсан гэрээ нь өөрөө хүчин төгөлдөр биш нөхцөлд гэрээнд хэрэглэх хуулийг салангид нь маргаангүй гэж үзнэ.

8 дугаар зүйл

Бусад орны хуулийг үл баримтлах

Талууд саналаа ямар нэгэн аргаар тодорхой илэрхийлээгүй бол талуудын сонгосон хуулийн олон улсын хувийн эрх зүйн дүрмийг баримтлахгүй.

9 дүгээр зүйл

Сонгосон хуулийн хамрах хүрээ

1. Талуудын сонгосон хууль нь талуудын хооронд байгуулагдсан гэрээний бүх асуудлыг зохицуулах бөгөөд дор дурьдсан асуудлаар хязгаарлагдахгүй.
Үүнд:
 - a. Гэрээний тайлбар,
 - b. Гэрээнээс үүсэх эрх, үүрэг,

- c. Гэрээний гүйцэтгэл болон гэрээг үл биелүүлснээс үүсэх үр дагавар, хохирлын үнэлгээ,
 - d. Үүргийг хүчингүй болгох олон талт арга зам болон түүний үндэслэл, хязгаарлалтын үе шат,
 - e. Гэрээний хүчин төгөлдөр байдал болон хүчин төгөлдөр бус гэрээний үр дагавар,
 - f. Нотлох баримт болон түүний хууль зүйн дүгнэлтийн тухай,
 - g. Гэрээ байгуулахаас өмнөх шатны үүрэг.
2. Энэ зүйлийн нэгдүгээр хэсгийн (e) дэх заалт нь гэрээг хүчин төгөлдөрт тооцож байгаа хуулийн хэрэглээг хязгаарлахгүй.

10 дугаар зүйл

Эрх шилжүүлэх

Зээлдэгч болон зээлдүүлэгчийн хооронд байгуулагдсан гэрээнээс үүссэн зээлдэгчийн эсрэг хэрэгжүүлэх зээлдүүлэгчийн эрхийг гэрээний дагуу шилжүүлэх тохиолдол. Үүнд:

- a) Хэрэв эрх шилжүүлэх гэрээний талууд гэрээг зохицуулах хуулийг сонгосон бол тухайн сонгосон хууль нь гэрээнээс үүссэн зээлдүүлэгч болон эрх хүлээн авагчийн харилцан хүлээх эрх, үүргийг зохицуулна.
- b) Хэрэв зээлдэгч, зээлдүүлэгч нь гэрээг зохицуулах хуулийг сонгосон бол тухайн сонгосон хууль нь дараах асуудлыг зохицуулна. Үүнд:
 - i. Зээлдэгчийн эсрэг эрх шилжүүлэлтийг хэрэгжүүлэх эсэх,
 - ii. Эрх хүлээн авагчийн зээлдэгчийн эсрэг эдлэх эрх,
 - iii. Зээлдэгч үүргээ гүйцэтгэсээр байх эсэх

11 дүгээр зүйл

Эн тэргүүний заавал биелэгдэх дүрэм болон олон нийтийн бодлого (ордре паблик)

- 1. Талуудын сонгосон хуулиас үл шалтгаалан шүүх тухайн хэргийг хянан шийдвэрлэх газрын эн тэргүүний заавал биелэгдэх хуулийн заалтуудыг хэрэглэхэд эдгээр зарчмууд нь саад болохгүй.
- 2. Хэргийг хянан шийдвэрлэх газрын хуулиар шүүх хэзээ хэргийг хянан шийдвэрлэх газрын хуулиас бусад хуулийн энэ тэргүүний заавал биелэгдэх заалтуудыг хэрэглэж болох, заавал хэрэглэх эсвэл харгалзан үзэхийг тогтооно.
- 3. Талуудын сонгосон хуулийг хэрэглэснээс үүсэх үр дагаврын хэмжээ зөвхөн хэргийг хянан шийдвэрлэх газрын олон нийтийн бодлогын суурь үнэт зүйлстэй илэрхий нийцэхгүй бол шүүх талуудын сонгосон хуулийн заалтуудыг хэрэглэхээс татгалзаж болно.

4. Шүүх тухайн улсын олон нийтийн бодлого (ордре паблик)-ыг хэрэглэж магадгүй эсвэл зайлшгүй хэрэглэх эсвэл харгалзан үзэх үедээ хэргийг хянан шийдвэрлэх газрын хуулиар гэрээнд хэрэглэх хуулийн зохицуулаагүй хэсэгт хэрэглэх хуулийг тогтооно.
5. Хэрэв арбитрын шүүх нь олон нийтийн бодлого (ордре паблик)-ыг хэрэглэх, эсвэл харгалзан үзэх түүнчлэн талуудын сонгосон хуулиас бусад хуулийн эн тэргүүний заавал биелэгдэх заалтуудыг хэрэглэх, эсвэл харгалзан үзэх шаардлагатай эсвэл тийм эрх олгогдсон бол эдгээр зарчмууд нь арбитрын шүүх үүнийг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

12 дугаар зүйл

Үйл ажиллагаа эрхлэх газар

Хэрэв гэрээний тал нэгээс олон газар үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг бол эдгээр зарчимтай холбогдох үйл ажиллагаа эрхлэх газар нь гэрээ байгуулахаар шийдвэрлэх тухайн цаг үед гэрээтэй хамгийн ойр холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа газар байна.